



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 44

Номгон

Үндсэн хөрөнгө балансаас  
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батласан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чандмань-Баянхонгор ХК-ний үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хавсралтад заагдсан 2 нэрийн 1144800 төгрөгийн өртөг бүхий илүүдэлтэй хөрөнгийг Баянхонгор аймаг дахь Төрийн Аудитын газарт балансаас балансад үнэ төлбөргүй шилжүүлсүгэй.

2. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх комисс томилж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх ажлыг, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018

0117371



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 02-ны  
өдрийн 44 дүгээр тогтоолын хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛСЭН  
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг /сум/- ын нэр	Байгууллагын нэр	Эд хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Ашиглах жил	Огноо	НБУ	Бүгд үнэ	Элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авсан байгууллагын нэр
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Баянхонгор аймаг	Чандмань- Баянхонгор ХК	Ширээ Э/З 2010	10.05.01	10	1	508800	508 800	402 800,00	106 000,00	Төрийн Аудитын газарт
2	Баянхонгор аймаг	Чандмань- Баянхонгор ХК	Ширээ дарга 2011	10.05.01	10	1	636000	636 000	503500	132 500,00	Төрийн Аудитын газарт
		ДҮН				2		1 144 800			